



УЛААНБААТАР ХОТЫН  
ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Анхны шатны тусламжийн эмийн санд  
эм, боох хэрэгслийг нөхөн бүрдүүлэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.8, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмын 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор анхан шатны тусламжийн эмийн санд эм, боох хэрэгсэл авч, нөхөн бүрдүүлж ажиллахыг Нярав /Н.Лхам/-т даалгасугай.

2. Дээрх эм, боох хэрэгсэл авахад шаардагдах 133,200 /нэг зуун гучин гурван мянга хоёр зуу/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /М.Ичинхорлоо/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий диспетчер /Г.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

215030175